

2024.12.06

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх, Гаалийн тухай хуулийн 277 дүгээр зүйлийн 271¹.1.2 дахь, Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005)-ийн 4 дүгээр хэсгийн 22 дугаар зүйл, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны... дугаар сарын....ны өдрийнтоот шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Тээврийн хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын зохицуулалттай холбогдуулан гаалийн байгууллагын цахим системүүдэд нэмэлт хөгжүүлэлт хийхийг Мэдээллийн технологийн газар /Б.Ганзориг/-т,

3. Халдваргүйжүүлэлтийн бодисын санхүүжилт, нөөц, ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Д.Долгорсүрэн/-т,

4. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, мөрдүүлж ажиллахыг Хяналт, бүрдүүлэлтийн газар /Б.Даваасүрэн/-т, харьяа гаалийн газар, хороодын дарга нарт тус тус даалгасугай.

5. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг /Захиргааны удирдлагын газар / Б.Хосбаяр/-т үүрэг болгосугай

6. Энэ тушаалыг 2025 оны дүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

АМЬТАН, УРГАМАЛ, ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ТЭЭВЭРЛЭХЭД ТАВИХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гаалийн хилээр амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлагатай холбоотой харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэхэд тусгайлан тавих шаардлага нь Олон улсын мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (WOAH) -ын хуурай газрын мал, амьтны эрүүл мэндийн кодекс, Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн хэлэлцээр (SPS), Ургамал хамгааллын олон улсын конвенц (IPPC)-ид заасан, Хүнсний эрх зүйн хороо (CAC)-ноос гаргасан шаардлага, зөвлөмжид нийцсэн байна.

1.3. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхээс өмнө холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагаас импортын мэдэгдэл, дамжуулан өнгөрүүлэх мэдэгдэл, экспортын гэрчилгээг урьдчилан авсан байна.

Хоёр. Тээвэрлэлтэд тавигдах тусгай шаардлага

2.1. Амьд мал, амьтныг тээвэрлэх иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага

2.1.1 Иргэн, хуулийн этгээд нь хилээр нэвтрүүлэх амьд мал, амьтны талаарх мэдээллийг гаалийн газар, хороонд 24 цагийн өмнө өгсөн байна.

2.1.2. Амьд мал, амьтныг улсын хилээр нэвтрүүлэх үед гаалийн газар, хорооны мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчаар анхдагч үзлэгийг хорио цээрийн байгууламж, гаалийн хяналтын тусгай бүс, талбайд хийлгүүлнэ.

2.1.3. Импортлогч иргэн, хуулийн этгээд нь амьд мал, амьтныг мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт гараагүй, голомт үүсээгүй тайван улс, бүсээс тухайн улсын эрх бүхий байгууллагын мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээтэйгээр тээвэрлэнэ.

2.1.4. Тээвэрлэлтийн өмнө тээврийн хэрэгслийг технологийн дагуу цэвэрлэн, халдваргүйжүүлснийг нотолсон халдваргүйжүүлэлтийн гэрчилгээг экспортлогч улсын мал эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагаас авсан байна.

2.1.5. Тээврийн хэрэгслийг мал, амьтны эрүүл, тавлаг байдлыг хангасан, агааржуулалт болон хэмийн тохируулгатай, зориулалтын дэвсгэр, зөөлөвч, өвс, сүрэл дэвсэж тоногдсон байна.

2.1.6. Тээврийн хэрэгслийн доторх эд анги, тоноглол нь хүн, мал, амьтны эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй материалиар хийгдсэн байна.

2.1.7. Нэг тээврийн хэрэгсэлд ачигдсан мал, амьтад нэг нэгийгээ гэмтээхгүй нөхцөлтэйгээр ачигдсан байна.

2.1.8. Тээвэрлэлтийн явцад мал, амьтныг хооллох, тэжээх болон услах, арчлах, эмчилгээ хийх зэрэг нөхцлийг бүрдүүлсэн байна.

2.1.9. Ачааны машин, чингэлэг, хашлагыг нээх үед амьтны хэвтэр, ялгадас бусад биологийн шингэн асгарахааргүй байх нөхцлийг бүрдүүлсэн байна.

2.1.10. Ачиж, буулгах тоноглол нь мал, амьтныг гэмтээхээргүй, гулгалт, хальтиргаа үүсгэхгүйгээр байна.

2.1.11. Тээвэрлэлтийн явцын маршрутын бүртгэл, тэмдэглэгээг тээврийн хэрэгслийн жолооч хөтөлсөн байна.

2.1.12. Тээвэрлэлтийн явцад малын эмч, эрх бүхий гаалийн улсын байцаагч үзлэг, шалгалт хийх боломжтой зай, талбайтай байна.

2.1.13. Тээвэрлэлтийн явцад үүсэж болзошгүй цаг агаарын таагүй үзэгдлийг зохицуулах болон гамшгийн аливаа нөхцөлд ажиллах бэлэн байдлыг хангасан байна.

2.1.14. Тээвэрлэлтийн хугацаанд өвдсөн, гэмтэж бэртсэн, хөдөлгөөний бэрхшээлтэй болсон мал, амьтныг тээвэрлэгч иргэн хуулийн этгээд гаалийн газар, хороодын мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчид мэдэгдэж, түүний хяналт дор орон нутгийн мал эмнэлгийн байгууллагад шилжүүлнэ.

2.1.15. Амьд мал, амьтныг хуурай замын боомтоор автомашинаар тээвэрлэх бусад тусгай шаардлага Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага /WOAH/-ын Газрын амьтны эрүүл мэндийн кодексын 7 дугаар бүлгийн 3 дэх хэсэгт заасан зөвлөмж, шаардлагад нийцсэн байна.

2.1.16. Амьд мал амьтныг агаарын хөлгөөр болон төмөр замаар тээвэрлэхэд тавих тусгай шаардлага нь Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага /WOAH/-ын Газрын амьтны эрүүл мэндийн кодексын 7 дугаар бүлгийн 4 дэх хэсэг болон мал эмнэлгийн асуудал эрхэлсэн мэргэжлийн байгууллагаас баталсан журам, заавраар зохицуулагдана.

2.2. Амьд мал, амьтныг тээвэрлэх үед гаалийн газар, хорооны мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчийн эрх, үүрэг

2.2.1 Амьд мал, амьтныг улсын хилээр нэвтрүүлэх үед гаалийн газар, хорооны мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч анхдагч үзлэгийг хорио цээрийн байгууламж, гаалийн хяналтын тусгай бүс, талбайд хийнэ.

2.2.2.Тээвэрлэлтийн өмнө тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн гэрчилгээг экспортлогч улсын мал эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагаас авсан эсэхийг шалгаж, баталгаажуулна.

2.2.3. Анхдагч үзлэг, шалгалтаар мал, амьтны гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн амьд мал, амьтнаас дээж, сорьц авч, мал эмнэлгийн магадлан шинжилгээнд хамруулан, баталгаажуулж, зориулалтын хорио цээрийн байгууламж, бүсэд түр тусгаарлан, тээвэрлэгч иргэн, хуулийн этгээд, гаалийн

газар, хороо болон гаалийн удирдах дээд байгууллага, мал эмнэлгийн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагад, шуурхай мэдэгдэнэ.

2.2.4. Магадлан шинжилгээгээр мал, амьтны гоц халдварт өвчний тохиолдол батлагдсан үед хорио цээрийн дэглэмд оруулж, түр тусгаарлан, орон нутгийн мал эмнэлгийн байгууллагад шилжүүлнэ.

2.2.5. Өвчний шинж тэмдэг бүхий мал амьтныг тээвэрлэж ирсэн тээврийн хэрэгсэл, тоноглол, ялгадас, хавьтал болсон талбайд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх явцад хяналт тавина.

2.2.6. Мал, амьтны гоц халдварт өвчнөөр өвчилсөн амьд, мал амьтныг экспортлогч талын мэргэжлийн байгууллагад мэдээлж буцаах, эсвэл тээвэрлэгч иргэн, хуулийн этгээдийн байлцуулан устгах арга хэмжээг зохион байгуулна.

2.3. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх иргэн, хуулийн этгээдэд тавигдах шаардлага

2.3.1. Тээвэрлэгч иргэн, хуулийн этгээд нь тээврийн хэрэгслийг улсын хилээр оруулахаас 24 цагийн өмнө гаалийн байгууллагад мэдэгдэнэ.

2.3.2. Импортын амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлийн дэгдэлт гараагүй тайван улс, бүсээс тээвэрлэсэн байна.

2.3.3. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, халуун, хүйтний хэмийг тохируулах боломжтойгоор тоноглогдсон зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

2.3.4. Тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл нь 2.3.4-д зааснаас гадна барааны төрлөөс хамааран өөр өөр байх ба холбогдох стандартуудад заасан шаардлагуудад нийцсэн байна.

2.3.5. Задгайгаар болон багцалж тээвэрлэсэн ургамлын гаралтай барааг ачсан тээврийн хэрэгсэл нь битүүмжлэлтэй, гадны бохирдлоос хамгаалсан зориулалтын бүтээлэгтэй байна.

2.3.6. Тээвэрлэлтийн өмнө тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн гэрчилгээг экспортлогч улсын эрх бүхий мэргэжлийн байгууллагаас авсан байна.

2.3.7. Барааны өрөлт, хураалтыг холбогдох стандартад нийцүүлэн гаалийн газар, хорооны эрх бүхий гаалийн улсын байцаагчийн үзлэг шалгалт хийх, магадлан шинжилгээнд хамруулах, сорьц, дээж авах нөхцөл, орон зайг бүрдүүлсэн байна.

2.3.8. Тухайн барааг бүтээгдэхүүний шинж чанарт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй бараатай хольж тээвэрлээгүй байна.

2.3.9. Боловсруулалт, тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл ялгаатай барааг нэг тээврийн хэрэгсэлд хамт ачигдахгүй нөхцлийг бүрдүүлсэн байна.

2.3.10. Барааг тээврийн хэрэгслийн лац, ломбо хөндөгдөөгүй, хашлага, сав, баглаа, боодлын бүрэн бүтэн байдал алдагдахгүй байдлаар тээвэрлэсэн байна.

2.3.11. Түргэн гэмтэх болон хэмийн горим шаарддаг бараанд хадгалалт, тээвэрлэлтийн үеийн бүртгэл, тэмдэглэгээг хөтөлсөн байна.

2.3.12. Ачааны машин, вагон, чингэлэг, хашлагыг нээх үед мал, амьтан, ургамал, ургамлын гаралтай задгай бараа асгарахааргүй нөхцлийг бүрдүүлж тээвэрлэгдсэн байна.

2.3.13. Экспортын амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тээвэрлэж байгаа тээврийн хэрэгсэл нь импортлогч улсаас тавигддаг ариутгал, халдваргүйжүүлэлт, хадгалалт тээвэрлэлтийн нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.3.14. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих бусад тусгай шаардлага нь мал эмнэлгийн болон ургамлын хорио цээрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан журам, зааварт нийцсэн байна.

2.4. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэх үед гаалийн газар, хорооны эрх бүхий гаалийн улсын байцаагчийн эрх, үүрэг

2.4.1 Тээвэрлэлтийн өмнө тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн гэрчилгээг экспортлогч улсын эрх бүхий мэргэжлийн байгууллагаас авсан эсэхийг шалгаж, баталгаажуулна.

2.4.2. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нь зориулалтын тээврийн хэрэгслээр барааны шошго дээр бичсэн температурын горимд нийцүүлэн тээвэрлэсэн эсэхэд хяналт тавина.

2.4.3. Тээвэрлэлтийн тусгай горим шаарддаг болон анх удаа импортолсон болон эрсдэл ихтэй бараанаас дээж сорьц авч, магадлан шинжилгээнд хамруулна.

2.4.4. Магадлан шинжилгээгээр мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио цээрийн шаардлага хангаагүй барааг халдваргүйжүүлэх, буцаах, устгах зэрэг хяналт, шалгалтын арга хэмжээг авна.

2.4.5. Ургамлын дотоод цээртэй зүйлс илэрсэн бараанд тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгэх явцад хяналт тавьж, гаалиас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэнэ.

2.4.6. Хадгалалт тээвэрлэлтийн горим зөрчсөн, илт муудаж, хөлдөж гэмтсэн эсвэл хими, биологийн бохирдолтой нь магадлан шинжилгээний дүнгээр батлагдсан тохиолдолд экспортлогч талын мэргэжлийн байгууллагад мэдээлж, буцаах, эсвэл тээвэрлэгч иргэн, хуулийн этгээдийн байлцуулан устгах арга хэмжээг зохион байгуулна.

Гурав. Хүлээх хариуцлага

3.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэн

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гаалийн хилээр нэвтрүүлэхээс өмнөх болон нэвтрүүлэх үед тээврийн хэрэгслийг халдваргүйжүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэх үйл ажиллагаа нь Олон улсын эрүүл мэндийн дүрэм (ОУЭМД-2005), Олон улсын мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын (WOAH) хуурай газрын мал, амьтны эрүүл мэндийн кодекс, Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн хэлэлцээр (SPS), Ургамал хамгааллын олон улсын конвенц (IPPC)-ид заасан зөвлөмж, шаардлагад нийцсэн байна.

1.3. Тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллага, мэргэшсэн ариутгалын ажилтан хийж, гүйцэтгэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд гаалийн газар, хорооны чиглэлийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч хяналт тавина.

Хоёр. Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллага, ариутгалын ажилтанд тавигдах нийтлэг шаардлага

2.1. Улсын бүртгэлд бүртгэгдсэн, хэрэглэх заавар батлагдсан, хүчинтэй хугацаатай, сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдаагүй, хаяг шошго нь тодорхой бодисыг ахалдваргүйжүүлэлтэд хэрэглэнэ.

2.2. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн уусмал бэлтгэх, халдваргүйжүүлэлт хийхэд өмсгөл, баг, хошуувч, амны хаалт, бээлий, хормогч зэрэг зориулалтын хувийн хамгаалах хувцсыг тухайн халдваргүйтгэлийн бодисын төрлөөс хамаарч сонгож хэрэглэнэ.

2.3. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг үйлдвэрлэгчийн заасан нөхцөлд хадгална.

2.4. Тээврийн хэрэгслийн халдварлагдсан байж болзошгүй хэсгүүдийг тухайн халдвар, ургамлын хорио зүйлсийг устгах, идэвхийг бууруулах шинж чанартай химийн болон химийн бус бодис ашиглан ариутгаж, халдваргүйжүүлнэ.

2.5. Халдварт өвчин тархсан, голомттой бүсээс ирсэн тээврийн хэрэгсэлд хийх халдваргүйжүүлэлтийг тухайн үйл ажиллагааг хариуцсан эрх бүхий байгууллагад мэдэгдэж, зохих шаардлагад нийцүүлэн холбогдох журам, зааварт нийцүүлэн хийнэ.

2.6. Халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг хилээр нэвтэрч буй тээврийн хэрэгслийн хөдөлгөөн урсгалд саад болохгүйгээр, орчин үеийн дэвшилтэт технологи, арга аргачлалд нийцүүлэн зохион байгуулна.

2.7.Халдваргүйжүүлэлтийн чанарт дотоодын хяналт тогтмол тавьж, хөндлөнгийн хяналтад хамрагдана.

Гурав. Гаалийн газар, хорооны эрх бүхий гаалийн улсын байцаагчийн эрх, үүрэг

3.1. Тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийг шүрших, туулуулах, мананцаржуулах, уураар утах хэт ягаан туяагаар шарах зэрэг хими, физикийн аргуудыг хослуулан хийхэд хяналт тавина.

3.2. Голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг халдварт өвчний сэжиг илэрсэн, голомт үүссэн, ургамлын гадаад хорио цээртэй зүйлсийн бохирдол илэрсэн тохиолдолд халдварын эх үүсвэр, дамжих зам, түүний тархалтыг таслан зогсооход чиглүүлнэ.

3.3. Халдварын голомттой бүс нутгаас ирсэн тээврийн хэрэгслийг голомтын эцсийн халдваргүйжүүлэлтэд хамруулахад хяналт тавина.

3.4. Амьд мал, амьтан тээвэрлэн ирсэн тээврийн хэрэгслэл, тоноглол, эд зүйлсийг улсын хилийн боомтод тусгайлан бэлтгэсэн ариун цэврийн бүс, талбайд шилжүүлж, урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг зөвшөөрөгдсөн бодисоор хийлгүүлнэ.

3.5. Үзлэг, шалгалт болон магадлан шинжилгээгээр ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд дотоод хорио цээртэй ургамлын өвчин, хог ургамал, хортон шавж, тэдгээрийн өндөг, авгалдай илэрсэн тохиолдолд тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн ариутгалын байгууллагаар халдваргүйжүүлэлт хийлгүүлж, хяналт тавина.

3.6. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортлогч улсаас ирүүлсэн мал эмнэлгийн гэрчилгээг шалгаж, тэдгээрийн тээвэрлэж буй тээврийн хэрэгсэлд урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг хийлгүүлнэ.

3.7. Мал, амьтны гоц халдварт өвчин бүртгэгдсэн бүс нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай боловсруулаагүй түүхий эд тээвэрлэгдэн ирсэн тохиолдолд улсын хилийн боомт дээр тээврийн хэрэгсэл, бараанд голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, экспортлогч улсад буцаах эсвэл устгах арга хэмжээг авна.

3.8. Экспортоор гарч байгаа тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн өмнөх халдваргүйжүүлэлтийг импортлогч талын эрх бүхий мэргэжлийн байгууллагаас тавьсан мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн шаардлагын дагуу хийнэ.

3.9. Экспортоор гарч байгаа мал, амьтан, ургамлын гаралтай бараанд импортлогч талын эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг хийлгүүлж, экспортын гэрчилгээ дээр тэмдэглэгээ хийнэ.

3.10. Экспортоор гарч байгаа тээврийн хэрэгслийн доторх гадарга, тавиур, поддон, тоноглолд импортлогч талын шаардлагын дагуу урьдчилан сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийлгүүлж, экспортын гэрчилгээ дээр тэмдэглэгээ хийнэ.

3.11. Экспортоор гарч буй мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаа нь хоёр талын гаалийн болон мэргэжлийн байгууллагатай хийсэн мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн нөхцөл, шаардлагыг тусгасан холбогдох протокол, санамж бичгийн заалтуудад нийцүүлэн хяналт тавина.

3.12. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал (олон улсын хөл хориот хүний өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, цацраг, химийн осол хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт гэх мэт) хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд үүссэн үед тээврийн хэрэгсэл, барааны ариутгал, халдваргүйжүүлэлтийг онцгой байдлын үед ажиллах үеийн горимд тохирсон холбогдох мэргэжлийн байгууллагаас баталсан журам, зааварт нийцүүлэн хийлгүүлнэ.

Дөрөв. Халдваргүйжүүлэлтийн чанар, үнэлгээ.

4.1. Тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны чанарт гаалийн газар, хорооноос дотоодын хяналт тавина.

4.2. Гаалийн газар, хороодод орон тоогоор ажиллаж буй ариутгалын ажилтанг мэргэжлийн байгууллагатай хамтран тухайн тухайн гаалийн газар, хорооноос сургалтад хамруулж, мэргэшүүлнэ.

4.3. Ариутгалын ажилтны халдваргүйжүүлэлтэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгслээр бүрэн хангаж, аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажил олгогчоос өгсөн байна.

4.4. Ариутгал, халдваргүйжүүлэлтэд энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан халдваргүйтгэлийн бодисыг хэрэглүүлнэ.

4.5. Халдваргүйтгэлийн бодисыг импортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагаас нийлүүлж, үйлдвэрлэгчийн зааварт тусгагдсан нөхцөлд хадгалж, зарцуулна.

4.6. Тээврийн хэрэгсэл, агуулах, талбайн шавж, мэрэгч устгах ажиллагааг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэхэд Гаалийн газар, хорооноос хяналт тавина.

4.7. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанаас үүссэн хатуу, шингэн тусгай хог хаягдлын зайлуулалтад гаалийн газар, хорооны чиглэл хариуцсан гаалийн улсын байцаагч хяналт тавина.

4.8. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт үнэлгээг хийлгэж болно.

4.9. Мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж нь харьяа гаалийн газар хороодын удирдлагатай халдваргүйжүүлэлтийн үйлчилгээ эрхлэх “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан ажиллаж болно.

Тав. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны санхүүжилт, бүртгэл, төлбөрийн баримт

5.1. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн төлбөр нь санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан жишиг үнэтэй нийцсэн

байна.

5.2. Гаалийн хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн бүртгэл, халдваргүйтгэлийн төлбөрийн нэхэмжлэл, нотломж олгох үйл ажиллагааг гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (CAIS)-ийг ашиглан цахим хэлбэрээр зохион байгуулна.

5.3. Гаалийн хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийсэн төлбөрийг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн урьдчилж төлж болно.

5.4. Гаалийн газар, хорооноос халдваргүйжүүлэлтийг өөрөө хийсэн тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлтийн үйлчилгээний орлого, зарлагын мэдээ тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр гаалийн удирдах төв байгууллагын санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан нэгжид ирүүлнэ.

5.5. Боомтын хүчин чадал, ачаа эргэлтээс хамаарч бараа, тээврийн хэрэгслийн халдваргүйжүүлэлтэд тохирсон байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглана.

5.6 Хилийн боомт, гаалийн хяналтын бүсэд мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлсийн голомт үүссэн үед тэдгээрийг цомхотгоход зарцуулагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Зургаа. Хүлээх хариуцлага

6.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.